



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/873

Ховд


Бүтцийг өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 438 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 3/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албаны эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагааны чиг үүргийг оновчтой болгож үр дүнгийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулан улс, орон нутгийн төсөв, бусад хөрөнгө оруулалтын худалдан авалтын үр ашгийг дээшлүүлэх, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Орон нутгийн өмчийн газар /Худалдан авах ажиллагааны албатай/-ын бүтцийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны алба гэж тус тус өөрчлөн зохион байгуулж ажиллуулсугай.

2. Шинэ бүтцээр ажиллах Худалдан авах ажиллагааны албаны дүрэм, бүтэц, зохион байгуулалт, орон тооны хязгаарыг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлд оруулан танилцуулж батлуулан хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлэх, хуучин Орон нутгийн өмчийн газарт ажиллаж байсан ажилтан, данс бүртгэлд байгаа өмч хөрөнгийг ажил үүргийн чиглэлээр зохих байгууллагуудад шилжүүлэн данс бүртгэлд тусгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/873 Ch

02 4321